

САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг¹ баталсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Энэхүү үнэлгээний зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын ачааллыг тооцож, цаашид гарах ачааллыг багасгах санал боловсруулахад оршино.

Уг аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус хуулийн төслөөр хувь хүнд бус санд болон төрийн байгууллагад зарим тодорхой зардал үүсгэхээр тусгасан байна.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- Хуулийн этгээд, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;²
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;³
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;⁴
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.⁵

Зардал тооцох үнэлгээтэй холбоотой тоон мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Сангийн яам болон Татварын ерөнхий газраас гаргуулан авсан болно.

Мөн тус хуулийн төслөөр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангахтай холбоотой зардлыг тооцохдоо(шаардлагатай материалын тоо ширхэг, хэмжээ болон зарцуулах

¹ Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн төсөл.2018 он. www.mojha.gov.mn,

² Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.3, 4.3 дахь зохицуулалт.

³ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.4.4, 4.4 дэх зохицуулалт.

⁴ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 4.4.3.1 дэх зохицуулалт.

⁵ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.1, 4.1 дэх зохицуулалт.

цагийн баримжаа зэрэг) ажиглалтын болон баримт бичиг судлах аргыг ашигласан болно.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хуулийн этгээдийн зардлыг тооцохдоо аргачлалын 2.1-д заасны дагуу

- 1) Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2) Зардлыг тооцох;
- 3) Тоон үзүүлэлтийг тооцох;
- 4) Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 5) Хялбарчлах боломжийг шалгах;
- 6) Нэмэлт зардлыг тооцох үе шатаар хуульд заасан үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарах мөнгөн зардлыг⁶ тооцсон.

Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөс шүүлт хийж үзэхэд санд⁷ шинээр тайлагнах болон шинэчилсэн бүртгэлд хамрагдах үүргийг шинээр хүлээсэн байна.

1.1. Сангийн тайлагнах үүрэгтэй холбоотой гарах зардал:

Хуулийн этгээд нь жилд 1 удаа үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргах бөгөөд тайланд үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал, зарцуулалтын талаар тусгахаар байна.⁸

Иймд тайлан гаргах үүрэгт дараахь агуулга багтаж байна хэмээн тооцлоо:

- 1.2.1. Мэдээлэл бэлтгэх;
- 1.2.2. Тайлан бичих;
- 1.2.3. Харьяа байгууллагад хүргүүлэх.

Үйл ажиллагааны тайлан:

Үүргийн агуулга	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/
Тайлан гаргахад бэлтгэх	Үйл ажиллагааны мэдээлэл	30 мин
	Мэдээллийг нэгтгэх	30 мин
Тайлан бичих		60 мин
Тайланг хянах		30 мин

⁶ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.3 дахь зохицуулалт.

⁷ “Гүйцэтгэх үүрэг” гэж тухайн хууль тогтоомжийн үйллэлд хамаарах этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.3 дахь хэсэг.

⁸ Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг.

Тайланг хүргүүлэх		10 мин
Нийт		160 мин буюу 2 цаг 40 мин

Санхүүгийн тайлан:

Үүргийн агуулга	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/
Тайлан гаргахад бэлтгэх	Мэдээлэл бэлтгэх	30 мин
	Мэдээллийг нэгтгэх	30 мин
Тайлан бичих		30 мин
Тайланг хянах		30 мин
Тайланг хүргүүлэх		10 мин
Нийт		130 мин буюу 2 цаг 10 мин

Тайланг жилд 1 удаа гаргах тул **ДАВТАМЖИЙН ТОО-г 1** гэж тооцлоо.

Иймд санд **жил тутамд** үйл ажиллагаа болон санхүүжилт болон зарцуулалтаа тайлагнах үүргээ хэрэгжүүлэхдээ нийт **290 минут буюу 4 цаг 50 минут** зарцуулна.

Төрийн бус байгууллагад ажиллаж байгаа ажилтны дундаж цалин хөлсийг **650,000** төгрөг гэж тооцлоо.⁹

Харин ажилтны сард ажиллах хугацаа нь **22 хоног буюу 176 цаг /10560 минут/** байна.

Үндсэн цалин	Ажиллах хугацаа	Ажлын хөлс
750 000	10560 минут	71 төг
750 000	290 минут /Дээрх ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хугацаа/	20.590 төг

Иймд энэхүү тайлагнах үүргийг сангаас жилд тус бүр нэг удаа гүйцэтгэх бөгөөд цалингийн зардал **20.590** төгрөгийг зарцуулахаар байна.

2021 оны 8 дугаар сарын 26441 төрийн бус байгууллагаас 1762 нь сан улсын бүртгэлд бүртгэлтэй байна.¹⁰

Дунджаар эдгээр байгууллагын 50% нь¹¹ идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг гэж үзээд **ТОХИОЛДЛЫН ТОО-г 896** гэж авсан болно.

Үүний дагуу нэг жилд 896 сангаас тайлагнах үүргээ хэрэгжүүлэхэд нийт 198.281.700 төгрөг зарцуулахаар байна.

⁹ Үнэлгээний хүрээнд хийсэн ярилцлагаас. 2018 он.

¹⁰ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн статистик мэдээ, 2018 он. УБЕГ.

¹¹ 2017 оны Статистикийн ерөнхий газрын мэдээлэлд дурдсанаар албан ёсоор бүртгэлтэй байгаа 17685 ТББ-ын 48.5% буюу 8578 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал. 2018 он. ХЗДХЯ.

1.2.Сангийн шинэчилсэн бүртгэлд хамрагдахтай холбоотой гарах зардал:

Хуулийн төслийн 26 дугаар зүйлийн 26.1-д зааснаар хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2 жилийн хугацаанд багтаж сан нь шинэчилсэн бүртгэлд хамрагдах үүрэг хүлээсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд шинэчилсэн бүртгэлд хамруулахд шаардлагатай бичиг баримт болон процессыг журамлсан зохицуулалт тусгагдаагүй байна.

Шинэчилсэн бүртгэл нь шинээр хуулийн этгээд үүсгэх биш хуулийн шинэчлэлд тусгагдсан нэмэлт шаардлагын дагуу дүрэмдээ холбогдох өөрчлөлтийг хийснээ бүртгүүлэх асуудал тул Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх журам үйлчилнэ гэж тооцлоо.

Иймд энэхүү үүргийн хүрээнд дараахь агуулга хамаарахаар байна:

- 1.Нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт, өдөр тутмын сонинд зарлуулсан зар;
- 2.Баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;
- 3.Үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай үүсгэн байгуулагч, эрх бүхий байгууллагын шийдвэр /тогтоол/, хурлын тэмдэглэл;
- 4.Үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан өөрчлөлт;
- 5.Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- 6.Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
- 7.Хуулийн этгээдийн хаягийн нотлох баримт;
- 8.Улсын бүртгэлийн гэрчилгээ.

Шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэх үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараахь захиргааны зардал гарахаар байна.

Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Хугацаа /мин	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Хуулийн этгээдийн шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэх	Нэрийн баталгаажуулалт хийлгэх	9630	40	1	40
	Өргөдөл бичих	9360	30	1	30
	Материалууд бүрдүүлэх	9630	120	1	120
	Улсын тэмдэгтийн хураамж төлөх;	9630	20	1	20

	Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлэх	9630	30	1	30
Нийт	240 минут буюу 4 цаг				

Санд ажиллаж байгаа мэргэжилтний дундаж цалин хөлсийг **750,000** төгрөг гэж тооцлоо.¹²

Харин ажилтны сард ажиллах хугацаа нь **22 хоног буюу 176 цаг /10560 минут/** байна.

Үндсэн цалин	Ажиллах хугацаа	Ажлын хөлс
750 000	10560 минут	71 төг
750 000	240 минут /Дээрх ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хугацаа/	17.040 төг

Иймд энэхүү үүргийг шашны байгууллагаас нэг удаа гүйцэтгэх бөгөөд **цалингийн зардал 17.040 төгрөгийг** зарцуулахаар байна.

Сангийн шинэчилсэн бүртгэлд хамруулахын тулд “Байгууллагын дүрэм” болон шаардлагатай бол үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах, нэр өөрчлөх бол нэрийн баталгаажуулалт хийх зэрэг ажиллагааг хийхээр байна.

Энэ хүрээнд дээрх баримт бичгийг хуульд нийцүүлэн боловсруулах, Удирдах байгууллагаа хуралдуулах зэрэг бэлтгэл ажиллагааг хангах шаардлагатай болно.

Гэвч эдгээр ажилд зарцуулах цаг хугацаа, зардал өөр өөр байх төдийгүй, хуулийн этгээдийн удирдах байгууллага нь жилд 1-ээс доошгүй удаа хуралдах, мөн хэлэлцэх асуудалд нь “Байгууллагын дүрэм”-ийн өөрчлөлт болон нэр өөрчлөх, үүсгэн байгуулах баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг нь хамаардаг.

Иймд дээрх шалтгааныг харгалзан холбогдон гарах зардлыг тооцоонд тусгаагүй болно.

Харин Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн¹³ 15 дугаар зүйлийн 15.1.1-т хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэхэд 44.000 төгрөгний хураамж төлөхөөр байна.

Иймд санг шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэхийн **ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ+ БОДИТ ЗАРДАЛ** шаардлагатай байна.

ЗАРЦУУЛАЛТ	ЗАРДАЛ
------------	--------

¹² Үнэлгээний хүрээнд хийсэн ярилцлагаас. 2021 он.

¹³ www.legalinfo.mn

1	Захиргааны зардал / цалин/	17.040 төгрөг
2	Шашны байгууллага байгуулах зөвшөөрөл авах /Улсын тэмдэгтийн хураамж/	44.000 төгрөг
4	Нийт	61.040 төгрөг

Сан нь тус хуулийн дагуу шинэчилсэн бүртгэлд хамрагдахын тулд **нэг удаа 61.040** төгрөгний зардал гарахаар байна.

Өнөөдөр бүртгэлтэй байгаа нийт сангийн¹⁴ 50 хувь нь тус шинэчилсэн бүртгэлд хамрагдана гэж тооцвол 896 хуулийн этгээдийн хувьд 54.691.840 төгрөг зарцуулахаар байна.

ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараахь үе шаттаар гүйцэтгэлээ:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийг хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягтлах.

Хуулийн төсөлд 47 дугаар зүйлд иргэний нийгмийн суурь хөгжлийн асуудлуудаар төртэй харилцах, зөвшилцөх, холбон ажиллах чиг үүрэг бүхий Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн чиг үүргийг тодорхойлсон байна.

Тус зөвлөл нь орон тооны бус бөгөөд Ажлын алба нь Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцэнд ажиллахаар зохицуулсан байна.

Иймд тус Ажлын албыг ажиллуулахтай холбоотой хүний нөөцийн болон захиргааны зардал гарахаар байна.

Тус ажлын албаны орон тоог Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоотой адилтган¹⁵ Ажлын албаны дарга-1, ахлах мэргэжилтэн-1, мэргэжилтэн-2 ажиллахаар тооцон гаргалаа.

¹⁴ 2021 оны 8 сарын байдлаар 1792 сан бүртгэлтэй байна. УБЕГ-ын мэдээлэл.

¹⁵ ХЗДХЯ-ны бүтэц, орон тооны мэдээлэл. 2018 он

Түүнчлэн зөвлөлийн дэргэдээ иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сантай байхаар зохицуулсан тул энэ чиг үүрэгт хамруулан ахлах мэргэжилтэн-1, мэргэжилтэн -1 нийт 2 орон тоо нэмэгдэнэ гэж тооцлоо.

Аргачлалд заасны дагуу албан ёсны эх сурвалжаас авсан тоо баримтыг эх сурвалж болгохоор заасан тул санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг албан хаагчид ногдох хүний нөөцийн хувьсах зардал болон материаллаг зардлын талаарх мэдээллийг авах шаардлагатай бөгөөд Сангийн яамнаас нэгдсэн байдлаар гаргасан тоо байхгүй талаар мэдэгдсэн болно.

Сангийн яам нь Төсвийг тооцоолохдоо тухайн байгууллагын чиг үүргийн онцлог, одоо байрлаж байгаа байрны байдал зэргээс хамааран байгууллага, байгууллагад харилцан адилгүй байдаг талаар мэдээлсэн болно.

Мөн энэ талаар Засгийн газрын 2002 оны “Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай” 120 дугаар тогтоолоор “Орон нутагт оршин суугаа 1000 хүнд ногдох удирдлагын хувьсах зардлын жишиг нормативыг Улаанбаатар хот 3300 төгрөг”-өөр тогтоосон боловч энэ нь 13 жилийн өмнө батлагдсан тул жишиг болгон ашиглах боломжгүй байна.

Дээрх тогтоолын дагуу төрийн албан хаагчийн өрөөний талбайн хэмжээ, тавилга хэрэгслийн нийтлэг жишгийг тогтоож өгсөн нь төрийн албан хаагчтай холбогдон гарах “материаллаг зардал”-ыг тооцоолоход ашиглаж болохоор байна.

Иймд нэг албан хаагчид оногдох материаллаг зардлыг тооцоолоход Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг удирдлага болгохын зэрэгцээ зардал тооцогдож байгаа байгууллагын санхүүгээс төсөв төлөвлөхөд ашигладаг норм, нормативыг харгалзан үзсэн болно.

Материаллаг зардал: Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын Дөрөвт:

Дэс түшмэл /түүнтэй адилтгах албан тушаалтан/		
Тавилга, хэрэгслийн төрөл		Тоо хэмжээ
1	Хувцасны өлгүүр (шүүгээ)	1
2	Шалны дэвсгэр	1
3	Бичгийн ширээ	1
4	Бичгийн ширээний иж бүрдэл	
5	Компьютер(иж бүрдэл)	1
6	Телефон утас	1
7	Тооны машин	1
8	Сэтгүүлийн ширээ	1
9	Компьютер	1
10	Бичиг хэрэг хадгалах шүүгээ	1

Нэг дэс түшмэлд ногдох албан ажлын өрөөний талбай дунджаар 8 ам метр байна. Хэд хэдэн ажилтан нэг өрөөнд суудаг бол дундаа ашиглах телефон утас, нэгдсэн холболт бүхий принтер, хувцасны өлгүүртэй байна.” гэж заасныг материаллаг зардлын тооцоог гаргахад ашиглав.

Иймд тус Ажлын албанд 8 ам метр бүхий 1 өрөө болон бичгийн ширээний иж бүрдэл-6, Компьютер (иж бүрдэл) -6, бичиг хэрэг хадгалах шүүгээ-6 шаардлагатай гэсэн тооцоо гарч байна.

Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай тухай Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоолоор төрийн захиргааны албан тушаалтны цалингийн сүлжээг шинэчлэн баталсан.

Үүний дагуу Ажлын албанд ажиллах албан тушаалтны цалинг дараахь байдлаар тооцож байна:

Ажлын албаны орон тоо		Албан тушаалын зэрэглэл	Цалин /сараар/
1	Ажлын албаны дарга	T3-10	845955
2	Ахлах мэргэжилтэн	T3-9	776279
3	Мэргэжилтэн	T3-8	716818

Хүний нөөцийн зардалд үндсэн цалингаас гадна бусад нэмэгдэл, төрөөс олгодог урамшуулал зэргийг оруулан тооцохоор аргачлалд заасан тул хүний нөөцийн дундаж зардлыг /+30.000 төгрөг/ тооцон нэмэхэд Ажлын албаны даргын нэг сарын цалин 900.000 төгрөг, ахлах мэргэжилтний нэг сарын цалин 800.000 төгрөг, мэргэжилтний нэг сарын цалин 750.000 төгрөг орчим байхаар байна.

Иймд Ажлын албанд зарцуулах нэг сарын цалин нийт 5.265.825 төгрөг, жилд 54.588.084 төгрөг байхаар байна.

Нэг сарын цалингийн тооцоо:

Ажлын албаны орон тоо		Цалин	Орон тоо	Нийт
1	Ажлын албаны дарга	845.955 төг	1	845.955 төг
2	Ахлах мэргэжилтэн	776.279 төг	2	1.552.558 төг
3	Мэргэжилтэн	716.818 төг	3	2.150.454 төг
Нийт				4.549.007 төг

Эдгээр зардал нь Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал тул хялбаршуулах, үүргийг нэгтгэн бууруулах боломжгүй хэмээн дүгнэж байна.

-----oOo-----

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Төрийн бус байгууллагын тухай хууль;
2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
3. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль;
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн статистик мэдээлэл. 2018 он;
5. Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл. 2021 он. ХЗДХЯ;
6. Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2021 он. ХЗДХЯ;
7. Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал. 2021 он. ХЗДХЯ
8. Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага, Тандан судалгаа хийсэн үнэлгээ. 2017 он. ШХА, ХЗДХЯ хамтарсан Иргэдийн оролцоо II төсөл.
9. Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн танилцуулга. 2021 он
10. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага: Үндэсний болон зарим орны эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа: 2018 он. Нээлттэй нийгэм форум
11. “Ашгийн бус байгууллын талаархи Монгол Улсын эрх зүйн зохицуулалт”. Эрх зүйн дүн шинжилгээ. 2017 он. ШХА, ХЗДХЯ хамтарсан Иргэдийн оролцоо II төсөл.
12. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол;
13. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал тооцох аргачлалын гарын авлага. 2016 он ХЗДХЯ.
14. Засгийн газрын 2002 оны “Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай” 120 дугаар тогтоол;
15. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоол.